



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/80

Шивээговь сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.1.3, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2020 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хийгдэх “Суманд гэрэлтүүлэг нэмэх” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Ж.Батмөнх

(Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга:

З.Баасандалай

(Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүн:

А.Нандинцэцэг

(1 дүгээр багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Хөндлөнгийн төлөөлөл:

Ц.Пүрэвням

(1 дүгээр багийн иргэн)

Ц.Эрдэнэбат

(1-р багийн иргэн)

2. Суманд гэрэлтүүлэг нэмэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хариуцлагатай зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг үнэлгээний хорооны дарга /Ж.Батмөнх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ

D:\My Documents\zaxiramj.doc

4212 021